



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ

2017 оны 07 сарын 17 өдөр

Дугаар 104

Номгон

“Соёлын ажилтан” аймгийн  
дэд хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ын “ж”, 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. “Соёлын ажилтан” аймгийн дэд хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.


2. Дэд хөтөлбөрт тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөө гаргаж, аймгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх жил бүрийн үндсэн чиглэлд тусгаж, шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг жил бүрийн төсөвт тусган батлуулж, хэрэгжилтийг бүтэн жилээр аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдэд танилцуулахыг аймгийн Засаг дарга /Г.Батжаргал/-д даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /С.Үнэнбуян/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Ц.ОТГОНБАЯР

0117261



## “СОЁЛЫН АЖИЛТАН” АЙМГИЙН ДЭД ХӨТӨЛБӨР

### НЭГ. СОЁЛ УРЛАГИЙН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Баянхонгор аймаг нь төв халхын соёлын голомт бүс нутаг гэдгээрээ ялгардаг. Төв халхын уртын дуу, морин хуур, магтаал, тууль зэрэг юугаар ч хэмжишгүй үнэт өв соёл энэ нутгийн голомтод өвлөгдөн үлдсэн байдаг.

Өнөөдөр Баянхонгор аймагт түүх соёлын үл хөдлөх 337 дурсгалт газрын 7548 дурсгал, соёлын биет бус 64 өвийн зүйлд 312 өвлөн уламжлагч албан ёсоор аймгийн бүртгэл мэдээллийн санд орсон байдаг.

Мэргэжлийн урлагийн 2 театр, нийтийн номын сан, музей, 19 суманд соёлын төвтэйгөөр соёл урлагийн үйлчилгээг хүргэж, жилд дундажаар 310 удаагийн урлагийн тоглолт, 2600 удаагийн соёл олон түмний арга хэмжээгээр давхардсан тоогоор 300 мянган хүнд үйлчилдэг. Мөн аймгийн хэмжээнд 13765 үзмэртэй ба жилд дундажаар 17000 хүнд аймгийн Музей, 16 сумын орон нутаг судлах танхимаар үйлчилдэг.

Аймгийн нийтийн номын сан, 19 сумын номын санд 154202 ширхэг номын фондтой ба давхардсан тоогоор 80 мянга гаруй хүнд 125 мянган ном олгож үйлчилдэг.

Соёл урлагийн 23 байгууллагад нийт 238 албан хаагч ажилладгаас уран бүтээлч мэргэжлийн албан хаагч 123, захиргаа аж ахуйн ажиллагсад 70, үйлчилгээ болон гэрээт албан хаагч 45 хүн ажиллаж байна. Үүнийг боловсролын түвшингээр авч үзвэл: магистр 1, бакалавр 75, дипломын дээд 26, тусгай дунд 22 хүн байна.

Соёл урлагийн мэргэжил шаардсан ажлын байр 166 үүнээс мэргэжлийн бакалавраас дээш зэрэгтэй 63, мэргэжлийн диплом, тусгай дунд мэргэжлийн үнэмлэхтэй 17, нийт мэргэжлийн боловсон хүчин 80 байх ба мэргэжилтэй ажилтны хангамж 48,1 хувьтай байна.

Соёл урлагийн мэргэжил тус бүрээр харуулбал:

#### Соёлын төвүүдэд шаардлагатай мэргэжлийн ажилтны хэрэгцээ

№	Ажлын байрны нэр	Байвал зохих	Одоо байгаа	Мэргэжлийн /бакалавраас дээш/	Диплом, тусгай дунд	Мэргэжлийн бус	Тэтгэвэрт гарах	Мэргэжил дээшлүүлэх /2017-2020/	2017	2018	2019	2020
1	Соёлын төвийн	19	19	9	3	7	1	11	-	5	3	3

	эрхлэгч											
2	Номын санч	19	19	12	3	4	-	7	3	2	2	-
3	Хөгжмийн багш	19	15	3	2	14	-	16	16	-	-	-
4	Бүжгийн багш	19	18	4	-	15	2	17	-	17	-	-
	Дүн	76	71	28	8	30	3	44	19	24	5	3

### Мэргэжлийн урлагийн байгууллагын мэргэжлийн ажилтны хэрэгцээ

№	Ажлын байрны нэр	Байвал зохих	Одоо байгаа	Мэргэжлийн /баклавраас дээш/	Диплом, тусгай дунд	Мэргэжлийн бус	Тэтгэвэрт гарах	Мэргэжил дээшлүүлэх /2017-2020/	2017	2018	2019	2020
1	Уран сайхны удирдагч	2	2	2	-	-	-	-	-	-	-	-
2	Ерөнхий найруулагч	2	2	2	-	-	-	-	-	-	-	-
3	Ерөнхий зураач	2	2	2	-	-	-	-	-	-	-	-
4	Концертмейстр	1	0	-	-	-	-	1	-	1	-	-
5	Хөгжмийн ерөнхий удирдаач	1	0	-	-	-	-	1	-	1	-	-
6	Бүжиг дэглэгч	2	2	2	-	-	-	-	-	-	-	-
7	Хормейстр	2	1	1	-	-	-	1	-	1	-	-
8	Хөгжмийн багш	3	3	1	2	-	1	3	2	1	-	-
9	Гэрэлтүүлэгч-техникч	2	2	-	-	2	1	2	-	2	-	-
10	Дууны инженер	2	2	-	-	2	-	2	-	2	-	-
	Дүн	19	16	10	2	4	1	10	2	8	-	-

### Мэргэжлийн урлагийн байгууллагын уран бүтээлчдийн хэрэгцээ

№	Ажлын байрны нэр	Байвал зохих	Одоо байгаа	Мэргэжлийн /баклавраас дээш/	Диплом, тусгай дунд	Мэргэжлийн бус	Тэтгэвэрт гарах	Мэргэжил дээшлүүлэх /2017-2020/	2017	2018	2019	2020
1	Хөгжимчин	18	12	2	1	9	-	10	10	-	-	-
2	Дуучин	12	9	5	-	4	-	4	-	2	2	-
3	Бүжигчин	16	12	3	3	6	-	9	4	2	2	1
4	Жүжигчин	13	13	7	1	5	-	6	2	2	2	-
5	Хөөмийч	2	2	2	-	-	-	-	-	-	-	-
	Дүн	61	48	19	5	24	-	29	16	6	6	1

### Номын сан, Музейн байгууллагын ажилтны хэрэгцээ

№	Ажлын байрны нэр	Байвал зохих	Одоо байгаа	Мэргэжлийн /баклавраас дээш/	Диплом, тусгай дунд	Мэргэжлийн бус	Тэтгэвэрт гарах	Мэргэжил дээшлүүлэх /2017-2020/	2017	2018	2019	2020
---	------------------	--------------	-------------	------------------------------	---------------------	----------------	-----------------	---------------------------------	------	------	------	------

1	Музейн эрхлэгч	1	1	-	-	1	-	1	1	-	-	-
2	Музейн ЭША	1	1	1	-	-	-	-	-	-	-	-
3	Сан хөмрөгч	1	1	1	-	-	-	-	-	-	-	-
4	Тайлбарлагч	1	1	1	-	-	-	-	-	-	-	-
5	Бүртгэл мэдээллийн санч	1	1	1	-	-	-	-	-	-	-	-
6	Номын сангийн эрхлэгч	1	1	1	-	-	-	-	-	-	-	-
7	Ном зүйч	1	1	-	1	-	-	1	-	1	-	-
8	Номын санч	2	2	1	-	1	-	1	1	-	-	-
9	Номын фондоч	1	1	-	1	-	-	1	-	1	-	-
		10	10	6	2	2	-	4	2	2	-	-

**Мэргэжлийн боловсон хүчний хангагдах боломж 2017-2020 оны хооронд:**

№	Ажлын байрны нэр	Байвал зохих	Одоо байгаа	Мэргэжил дээшлүүлэх шаардлагатай	Давтан сурах шаардлагатай	Мэргэжил дээшлүүлэх /2017-2020/	2017	2018	2019	2020
1	Мэргэжлийн боловсон хүчний өнөөгийн байдал /нийт дүнгээр/	166	145	64	17	93	39	40	11	3

Дээрх мэдээллүүдээс харахад соёл урлагийн салбарт ажиллах хүний нөөц болон орон тоо хангалтгүй, мэргэжлийн боловсон хүчний дутагдалтай хэдий ч иргэдэд хүргэх соёлын үйлчилгээг тасралтгүй хүргэсээр байна.

Гэсэн хэдий ч тухайн нутаг дэвсгэр дээрх өв соёлын өвөрмөц хэв шинжийг алдагдуулалгүйгээр орчин үеийн урлаг соёл, технологийн дэвшилтэй хослуулан хөгжүүлэх, соёлын үйлчилгээний уламжлалт хэлбэрийг өөрчлөн шинэ хандлага, шинэ менежмент маркетингаар ажиллах дэлхий нийтийн чиг хандлага Монгол улсад бий болсон учир бид орон нутгийнхаа соёлын ажилтнуудын мэдлэг боловсролыг дээшлүүлэх, тэднийг тасралтгүй хөгжүүлэх үйл ажиллагааг бодлогоор хэрэгжүүлэх шаардлагатай болжээ.

Соёл урлагийн салбарт ажиллагсадын цалин хөлс, нийгмийн асуудал бусад салбаруудаас харьцангуй доогуур үнэлэгдэж, төрийн бодлогод дорвитой тусгагдаж шийдвэрлэгдэхгүй байгаа нь энэ салбарт ажиллагсадын итгэл үнэмшлийг улам сааруулсаар байна.

Тухайлбал: Эрүүл мэнд, боловсролын салбарын ажилтнууд нь илүү цаг, хөдөө орон нутагт ажилласан жилийн нэмэгдэл, тэтгэвэрт гарахад олгогдох тэтгэмж зэрэг нь тухайн салбарт ажиллаж буй ажиллагсдын нийгмийн асуудлыг дорвитой шийдвэрлэсэн байхад соёл урлагийн салбарт эдгээр тэтгэмж, урамшууллыг шийдвэрлээгүй төдийгүй, цалин хөлс нь харьцангуй бага байна.

Иймээс соёлын ажилтныг төр ивээлдээ авч тэдний орон нутагт ажиллах амьдрах итгэл үнэмшил, үнэлэмжийг нэмэгдүүлэхэд анхаарах орон нутгийн хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх шаардлагатай юм.

### **ХОЁР. ХӨТӨЛБӨРИЙН ЭРХ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ**

Соёлын тухай хуулийн 6 дугаар бүлгийн 22 дугаар зүйлд “нэмэгдэл цалин, урамшил, эрдмийн зэрэг, цолны болон ур чадварын нэмэгдэл олгох, ажлын онцлогоос шалтгаалан хөдөлмөрийн чадвараа эрт алдсан ажилтныг, тусгай мэргэжил эзэмших зардлыг төр хариуцах, онцгой амжилт гаргасан соёлын ажилтан, уран бүтээлчдэд мөнгөн шагнал олгох” гэж,

Монгол Улсын Их хурлын 2012 оны 52 дугаар тогтоолоор баталсан төрөөс баримтлах соёлын бодлогод “Соёлын ажилтны нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд нь бодитой туслалцаа дэмжлэг үзүүлэх, орон нутгийн соёл урлагийн байгууллагыг мэргэжлийн ажилтнаар бүрэн хангаж, тэднийг тогтвор суурьшилтай ажиллуулах, соёл урлагийн ажилтны мэргэжил олгох, давтан болон мэргэшил дээшлүүлэх сургалтын шинэ тогтолцоо бүрдүүлэх” гэж,

Засгийн газрын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт “Соёлын салбарын ажиллагчдын хөдөлмөрийн үнэлэмжийг дээшлүүлнэ” гэж,

Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Соёл урлагийн шилдэг ажилтан мэргэжилтнүүдийг гадаадад мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулж, орон нутагт ажиллуулах бодлого хэрэгжүүлнэ.” гэж тус тус заасан байна.

### **ГУРАВ. ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА**

Аливаа улс, үндэстний соёл урлагийн хөгжлийн түвшин нь тухайн үндэстний тусгаар тогтнол, соёл иргэншил, боловсрол, ёс заншил, түүх, нийгэм, улс төр, эдийн засгийн харилцаа зэргийн хөгжлийн чиг хандлагыг илэрхийлдэг.

Сүүлийн жилүүдэд соёл урлагийн салбарт төрөөс хэрэгжүүлж буй үзэл санаа нь үндэсний өв соёлыг дэлхийн соёл урлагийн шилдэг ололтоор баяжуулан, соёлын үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиг хандлагыг нэвтрүүлэхэд чиглэгдэж байна. Үүнийг хэрэгжүүлэхэд зайлшгүй мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэн тогтвор суурьшилтай ажиллуулах бодлогыг хэрэгжүүлэх шаардлагатай юм.

Аймгийн соёл урлагийн салбарын мэргэжилтэй ажилтны хангамж, мэргэшсэн туршлагатай боловсон хүчин, соёлын ажилтны нийгмийн баталгаа зэргийн өнөөгийн бодит түвшинд тулгуурлан энэхүү хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх хэрэгцээ бий болсон.

Баянхонгор аймагт соёл урлагийн салбарыг хөгжүүлэх бодлого, чиглэлийг аймгийн хөгжлийн хөтөлбөрт тодорхойлж, жил бүрийн аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусган ажилласаар ирсэн билээ.

Гэсэн хэдий ч соёл урлагийн салбарын бүх шатанд соёлын ажилтны ур чадвар, мэргэжил мэдлэгийг дээшлүүлэх, мэргэжилгүй албан хаагчдын боловсролын зэргийг ахиулах, тогтвор суурьшилтай ажиллуулах, нийгмийн асуудлыг шийдвэрлэх, эдийн засаг санхүүгийн нөөц боломжийг төлөвлөх, хүн амд хүргэх соёл урлагийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх зэрэг асуудлууд бүрэн шийдвэрлэгдээгүй байна.

Соёл урлагийн байгууллагуудад үйл ажиллагаагаа хэвийн явуулахад шаардагдах санхүүжилт, барилга, тоног төхөөрөмж, материаллаг бааз жилээс жилд нэмэгдэж байгаа хэдий ч үйл ажиллагаагаа тогтмол бус, уран бүтээл үйлчилгээний чанар тааруу, мэргэжлийн боловсон хүчин хангалтгүй, контент маркетинг болон соёл урлагийг хөгжүүлэх ажил хийхэд мэргэшсэн туршлагатай боловсон хүчний дутагдалтай зэрэг зөрчил дутагдал байсаар байна.

Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн Г-53 дахь заалт болон аймгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх 2017 оны үндсэн чиглэлийн 49 дугаар хэсэгт аймгийн “Соёлын ажилтан” хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэхээр тусгагдсан нь хөтөлбөр боловсруулах хэрэгцээ шаардлага болсон.

Соёл урлагийн салбарын мэргэжлийн боловсон хүчний хангамжийг нэмэгдүүлэн, тогтвор суурьшилтай ажиллуулах, мэдлэг боловсролыг нь тогтмол дээшлүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлж, төр, иргэн, нийгмийн хамтын уялдаа холбоог сайжруулах, иргэдэд хүргэх соёлын үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэн, соёлын үйлчилгээний үр өгөөжийг нэмэгдүүлэх зорилгоор “Соёлын ажилтан” хөтөлбөрийг боловсруулсан.

## **ДӨРӨВ. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО, БАРИМТЛАХ ЗАРЧИМ, ХУГАЦАА**

### **4.1 Хөтөлбөрийн зорилго**

Соёл урлагийн талаар төрөөс баримталж буй бодлогыг орон нутгийн түвшинд системтэйгээр хэрэгжүүлэн соёлын ажилтны чадавхыг дээшлүүлснээр тогтсон үйлчилгээ, шинэлэг контентуудыг бий болгож, соёл урлагийн салбарын үнэ цэнийг бэхжүүлэхэд энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

### **4.2. Хөтөлбөр хэрэгжүүлэхэд баримтлах зарчим**

Хөтөлбөрийг дор дурдсан үндсэн зарчим дээр тулгуурлан хэрэгжүүлнэ.

4.2.1. Орон нутгийн онцлог хэрэгцээ шаардлагад нийцсэн хөгжлийн болон салбарын бодлогыг дэмжих, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, үндсэн чиглэл зэрэг бодлогын баримт бичигүүдтэй уялдах;

4.2.2. Соёлын ажилтныг бүхий л талаар хөгжүүлэх үйл ажиллагааг соёл урлагийн байгууллагууд болон гадаад дотоодын хамтын ажиллагаанд тулгуурлан зохион байгуулах:

4.2.3. Соёлын ажилтны хөгжил дэвшил нь соёл урлагийн үйлчилгээг дээшлүүлэхэд хэрхэн нөлөөлж буй талаар бодитой судалгааг гаргах;

#### **4.3 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа:**

4.3.1. “Соёлын ажилтан” хөтөлбөрийг 2017-2020 он хүртэл хэрэгжүүлнэ.

### **ТАВ. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТ, ҮР ДҮН, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА**

**Зорилт 1:** Соёл урлагийн салбарын мэргэжилтэй ажилтны хангамж, соёл урлагийн байгууллагад нэн шаардлагатай орон тоог нэмэгдүүлэх, соёлын ажилтны чадавхыг дээшлүүлэх сургалтуудыг үе шаттай зохион байгуулах

#### **Зорилтыг хэрэгжүүлсний дараах үр дүн:**

Мэргэжилтэй ажилтны хангамж 90%-д хүрч, мэргэшсэн, чадварлаг боловсон хүчнээр хангагдаж, соёл урлагийн бие даасан контентууд бий болж, Баянхонгор гэсэн соёл урлагийн нэрийн бүтээгдэхүүнүүд үйлдвэрлэгдэнэ.

#### **Зорилт 1-ийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

1.1. Соёл урлагийн байгууллагуудыг ажиллагсдын дэлгэрэнгүй судалгаа, мэдээллийн баазыг бүрдүүлэх, мэргэжлийн боловсон хүчний хангамжийг судлах

1.2. Мэргэжлийн боловсон хүчний хангамжийг нэмэгдүүлэх талаар Соёл урлагийн их сургуультай хамтран соёл урлагийн мэргэжлүүдээр эчнээ, зайн хөтөлбөрт мэргэжилгүй албан хаагчдыг хамруулах, зарим хөтөлбөрийг орон нутагт хичээллүүлэх

1.3. Шаардлагатай мэргэжлүүдээр гадаадад мэргэжилтэн бэлтгэн орон нутагт ажиллуулах

1.4. Соёл урлагийн байгууллагуудад дутагдалтай байгаа нэн шаардлагатай орон тоо, боловсон хүчнийг нэмэгдүүлэх

1.5. “Соёлын ажилтны чадавхыг бэхжүүлэх нь” сэдэвт соёлын ажилтны зөвлөгөөн, мэргэшүүлэх сургалтуудыг жил бүр үе шаттай зохион байгуулах

1.6. “Соёлын биет бус өвийн хадгалалт хамгаалалт, бүртгэн баримтжуулалт” сургалтыг үе шаттай зохион байгуулж, соёлын өвийн ажилтнуудыг бэлтгэнэ.

1.7. Хөгжмийн багш, бүжгийн багш, номын санчийг чадваржуулах сургалтыг жил бүр зохион байгуулна.

1.8. Угийн бичиг хөтлөлтийг эрчимжүүлэх чиглэлээр сумын Засаг дарга, багийн Засаг дарга, соёлын ажилтнуудад сургалт зохион байгуулж, “Ургаа мэдье–Удмаа

бататгая” аяныг жил бүр зохион байгуулж хэвшүүлэн, угийн бичгийн нэгдсэн мэдээллийн баазыг бүрдүүлнэ.

**Зорилт 2:** Соёлын ажилтны нийгмийн асуудлыг шийдвэрлэн хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажиллах боломжийг бүрдүүлэх, соёлын байгууллагын орчин нөхцлийг сайжруулах

**Зорилтыг хэрэгжүүлсний дараах үр дүн:**

Соёл урлагийн салбарын нийгэмд эзлэх үнэлэмж өсөж, эрүүл чийрэг бие бялдар, сэтгэл ханамж, итгэл үнэмшилтэй, тогтвор суурьшилтай ажиллах соёлын ажилтан, уран бүтээлчид бий болно. Хөдөө орон нутгийн соёлын үйлчилгээний чанар хүртээмж дээшилж, шинэ шатанд гарна.

**Зорилт 2-ыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

2.1. “Нийтийн соёл ба эрүүл, аюулгүй орчин” загвар төсөл боловсруулан, соёлын байгуулагуудын орчин нөхцлийг сайжруулах, үйлчилгээ болон үйлчлүүлэгчдийн соёлын харилцааг бүрдүүлэх

2.2. Соёлын ажилтныг жил бүр тогтмол эрүүл мэндийн үзлэгт хамруулж, эрүүл үйлчилгээг бий болгох

2.3. “Соёл-Хотхон” орон сууцыг барьж, хөнгөлөлттэй үнээр ашиглалтад оруулах ажлыг эхлүүлэх

2.4. Соёл урлагийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй төрийн бус байгууллага, холбоодын үйл ажиллагааг дэмжих

**Зорилт 3:** Соёлын ажилтны ур чадварыг үнэлж дүгнэх, хариуцлагыг өндөржүүлэх, өндөр ур чадвартай, онцгой амжилт үзүүлсэн соёлын ажилтан, уран бүтээлчдийг урамшуулах

**Зорилтыг хэрэгжүүлсний дараах үр дүн:**

Соёл урлагийн байгууллагад ажиллагсдын ур чадвар өсөн нэмэгдэж, ажлын хариуцлага сайжирснаар уран бүтээлийн чанар нэмэгдэнэ.

**Зорилт 3-ын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

3.1. Соёл урлагийн бодлогын зөвлөл, дэд зөвлөлүүдийг байгуулан ажиллах

3.2. Соёлын ажилтан, уран бүтээлч, багш нарын дунд 2 жил тутамд ур чадварын уралдаан зарлан дүгнэх

3.3. Соёл урлагийн мэргэжлийн ажлын байранд ажиллагсдын дунд 4 жил тутамд адестачлал зохион байгуулах

3.4. Соёлын ажилтны ёс зүйн дүрмийг гарган, мөрдөн ажиллах

3.5. Өндөр ур чадвартай, онцгой амжилт үзүүлсэн соёлын ажилтныг урамшуулах журмыг боловсруулан хэрэгжүүлэх

**Зорилт 4:** Мэргэжлийн чиглэл тус бүрээр гадаад дотоодод туршлага судлуулан соёлын ажилтнуудын мэдлэг, туршлагыг нэмэгдүүлэх

**Зорилтыг хэрэгжүүлсний дараах үр дүн:**

Гадаад дотоодын соёл урлагийн үйлчилгээ, уран бүтээлээс суралцаж соёлын ажилтан, уран бүтээлчдийн ур чадвар, ажлын туршлага сайжирч шинэлэг үйлчилгээг нэвтрүүлнэ.

**Зорилт 4-ийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

4.1. Соёл урлагийн үйлчилгээний голлох бүтээгдэхүүн хэрэгцээг тодорхойлж, судлан шинжлэх, хэрэгжүүлэх арга замыг нэвтрүүлэх

4.2. “Соёлын ажилтны солилцоо” арга хэмжээг соёлын төвүүдийн дунд болон гадаад дотоодын соёл урлагийн байгууллагуудтай харилцан солилцоо хийх ажлыг хэрэгжүүлэх

4.3. Мэргэжил тус бүрээр гадаад дотоодод туршлага судлуулан хамтын ажиллагааг сайжруулж, соёлын ажилтнуудын мэдлэг, чадварыг дээшлүүлэх

4.4. Хил залгаа аймгуудтай хамтарсан соёл урлагийн арга хэмжээ зохион байгуулах, харилцан туршлага судлах

**ЗУРГАА. ХӨТӨЛБӨРИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

6.1. Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь Монгол Улсын хууль тогтоомж, эрх зүйн акт болон бусад баримт бичгийн дагуу зохион байгуулагдана.

6.2. Хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах аймгийн бодлогын зөвлөлийг байгуулан аймгийн Засаг даргын орлогч ахлаж бүрэлдэхүүнд нь Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлогын хэлтэс, Боловсрол, соёл урлагийн газар, соёл урлагийн байгууллагуудын удирдлага, соёл урлагийн холбоодын тэргүүн, орон нутгийн хэвлэл мэдээллийн ажилтнууд багтсан байх ба аймгийн Засаг даргын захирамжаар үүрэгжүүлэн хяналт тавих ажлыг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга хариуцна.

6.3. Хөтөлбөрийн үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөө гаргаж, аймгийн Засаг даргын зөвлөлөөр хэлэлцүүлэн баталгаажуулж бүх сум, соёл урлагийн байгууллагуудад хүргүүлнэ.

6.4. Хөтөлбөр хэрэгжүүлэх ажлын нэгдсэн төлөвлөгөөг хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагааг гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт бүрээр төлөвлөн эзэнжүүлж, удирдлага, төлөвлөлтөөр хангах, зохицуулах, хэрэгжилтэд хяналт тавих үүргийг соёлын асуудал хариуцсан бодлогын хэлтэс, хэрэгжүүлэгч агентлаг хариуцна.

6.5. Хөтөлбөрийн холбогдох заалтуудыг сумдын Засаг дарга нартай байгуулах үр дүнгийн гэрээнд тусгуулан хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

6.6.Хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг жил бүр аймгийн Засаг даргын зөвлөлөөр хэлэлцүүлсний дараа аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанд оруулан дүгнүүлнэ.

### **ДОЛОО. ХӨТӨЛБӨРИЙН ХАМРАХ ХҮРЭЭ, САНХҮҮЖИЛТ, ТӨСӨВ**

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг аймгийн Засаг даргаас баталсан тухайн жилийн төлөвлөгөөг үндэслэн зохион байгуулна.

“Соёлын ажилтан” хөтөлбөрийг дараах хөрөнгийн эх үүсвэрээр санхүүжүүлнэ.

1. Орон нутгийн төсөв
2. Засаг даргын нөөц хөрөнгө
3. Соёл урлагийн байгууллагууд
4. Хандив

### **НАЙМ. ХӨТӨЛБӨРИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ**

Хөтөлбөрийн хэрэгжилтийг дараах шалгуур үзүүлэлтээр дүгнэнэ.

- 8.1.Мэргэжилтэй ажилтны хангамжийн хувь, боловсон хүчнээр хангасан байдал
- 8.2.Соёлын ажилтнуудад мэргэшүүлэх, ур чадвар олгох сургалтууд зохион байгуулагдаж, түүнд хамрагдсан байдал, гарсан үр дүн
- 8.3.Гадаад дотоодод туршлага судалж, түүнийгээ ажилдаа нэвтрүүлсэн үр нөлөө
- 8.4.Төр, иргэн, нийгмээс соёлын талаарх үнэлэмжид өгсөн үнэлгээ, тандалтын судалгааны дүн
- 8.5.Соёл урлагийн байгууллагуудын орчин, үйлчилгээнд гарсан өөрчлөлт
- 8.6.Соёлын ажилтны нийгмийн хангамжинд гарсан үр нөлөө

-----oOo-----